



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 25 өдөр

Дугаар A/126

Арвайхээр

Өвс, тэжээл хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.5, 32.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын Гамшгийн хохирлыг барагдуулах зарим арга хэмжээний тухай 2020 оны 85 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилт хүндэрсэн зарим сумдад аймгийн Улсын нөөцийн салбараас 50 хувь хямдруулан олгох тэжээл, үнэгүй олгох өвсний хуваарийг нэгдүгээр, тээврийн зардлыг хоёрдугаар, дээрх сумдад хуваарилсан нөөцийн барааны түгээлтэд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Өвөлжилт хүндэрсэн сумдад өвс, тэжээл хүргэх тээврийн зардал 7.800.000 (долоон сая найман зуу) төгрөгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Онцгой байдлын газрын дарга, (дэд хурандаа Т.Мөнхдорж)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100275

Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 41/26 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЛСЫН НӨӨЦИЙН САЛБАР ЦЭГЭЭС СУМДАД
ТУСЛАМЖ ХЭЛБЭРЭЭР ҮНЭГҮЙ ОЛГОХ ӨВСНИЙ ХУВААРЬ

А. Үнэгүй олгох өвсний хуваарь

д/д	Сумын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
ОБГ-ын 048-р цэг			
1	Хайрхандулаан	тн	22.6
2	Богд	тн	12
3	Нарийнтээл	тн	11.8
	Нийт	тн	46.4
ОБГ-ын 022-р цэг			
7	Баян-Өндөр	тн	15
8	Бүрд	тн	15
9	Баянгол	тн	15
10	Ёсөнзүйл	тн	15
11	Гучин-Ус	тн	16
12	Өлзийт	тн	16
13	Сант	тн	16
	Нийт	тн	108
	Өвс нийт дүн	тн	154.4

Б. 50 хувь хямдралтай олгох тэжээлийн хуваарь

д/д	Сумын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг тонн	Бүгд үнэ
ОБГ-ын 072-р цэг					
1	Арвайхээр	тн	11	220000	2.420.000
2	Тарагт	тн	11	220000	2.420.000
	Нийт	тн	22	220000	4.840.000
ОБГ-ын 136-р салбар					
4	Баян-Өндөр	тн	12.5	220000	2.750.000
5	Бүрд	тн	7.5	220000	1.650.000
		тн	5	262500	1.312.500
6	Ёсөнзүйл	тн	20	220000	4.400.000
	Нийт	тн	45		10.112.500
ОБГ-ын 022-р цэг					
6	Сант	тн	12.5	220000	2.750.000
7	Баянгол	тн	19.5	220000	4.290.000
	Нийт	тн	32	220000	7.040.000
ОБГ-ын 048-р цэг					
8	Нарийнтээл	тн	20	220000	4.400.000
9	Баруунбаян-Улаан	тн	20	220000	4.400.000
			1	270000	270.000
10	Гучин-Ус	тн	12.5	302500	3.781.250
11	Богд	тн	12.5	302500	3.781.250

12	Уянга	тн	12.5	302500	3.781.250
13	Хайрхандулаан	тн	12.5	302500	3.781.250
нийт		тн	91		24.195.000
Нийт хэвэг дүн		тн	190		46.187.500

В. 50 хувь хямдралтай олгох хорголжин тэжээлийн хуваарь


д/д	Сумын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг тонн	Бүгд үнэ
ОБГ-ын 072-р цэг					
1	Арвайхээр	тн	16	299300	4.788.800
2	Тарагт	тн	12	299300	3.591.600
3	Хайрхандулаан	тн	12	299300	3.591.600
4	Уянга	тн	12	299300	3.591.600
5	Нарийнтээл	тн	12	299300	3.591.600
6	Богд	тн	12	299300	3.591.600
7	Гучин-Ус	тн	12	299300	3.591.600
8	Баруунбаян-Улаан	тн	12	299300	3.591.600
Нийт		тн	100		29.930.000
ОБГ-ын 022-р цэг					
9	Сант	тн	12	300000	3.600.000
10	Төгрөг	тн	12	300000	3.600.000
11	Өлзийт	тн	12	300000	3.600.000
12	Ёсөнзүйл	тн	12	300000	3.600.000
13	Баянгол	тн	12	300000	3.600.000
14	Бүрд	тн	24	300000	7.200.000
15	Баян-Өндөр	тн	12	300000	3.600.000
нийт		тн	96		28.800.000
Нийт хорголжин дүн		тн	196		58.730.000

Аймгийн Засаг даргын 2020 оны 03
дугаар сарын 25 -ны өдрийн 1196 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ӨВӨЛЖИЛТ ХҮНДЭРСЭН СУМДУУДАД ӨВС, ТЭЖЭЭЛ
ХҮРГЭХ ТЭЭВРИЙН ЗАРДАЛ

д/д	Сумдын нэр	Нийт явах зам /км/	Тээвэрлэх автомашины тоо	Тээврийн хөлс /төг/
1	Баян-Өндөр	430	1	1.400.000
2	Бүрд	430	1	1.500.000
3	Баянгол	430	1	1.500.000
4	Ёсөнзүйл	430	1	1.400.000
5	Гучин-Ус	430	1	1.400.000
	Нийт	2150	5	5.700.000
Тухайн өвс тэжээл авсан цэгээс 100 км-ээс дээших зайд байрлах сумдад олгосон шатахууны зардал				
1	Богд			300.000
2	Төгрөг			300.000
3	Уянга			150.000
4	Бүрд			300.000
5	Ёсөнзүйл			150.000
6	Гучин-Ус			300.000
7	Баруунбаян-Улаан			300.000
8	Нарийнтээл			300.000
	Нийт			2.100.000

Аймгийн Засаг даргын 2020 оны 03
дугаар сарын 25-ны өдрийн 7/136 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН НӨӨЦИЙН ЦЭГЭЭС ОЛГОХ
ӨВСНИЙ ТҮГЭЭЛТИЙН БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Т. Мөнхдорж –аймгийн Онцгой байдлын газрын дарга
Гишүүд: С.Цэдэнбалжир -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж

ахуйн газрын дарга

С. Дуламсүрэн -аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын
газрын дарга

Б. Ундармаа –аймгийн Онцгой байдлын газрын, Улсын нөөцийн
салбарын дарга

Н. Үл-Олдох -аймгийн Цагдаагийн газрын эдийн засгийн мөрдөгч